

## БНХАУ-ЫН ХӨХ НУУР МУЖИЙН ТАЛААР ТОВЧ ӨГҮҮЛЭХ НЬ

*Н.Төмөр\**

БНХАУ-ын төлөвлөгөөт эдийн засгийн өөрийн онцлог, зах зээлийн чөлөөт эдийн засагтай уялдуулан өөрчлөлт шинэчлэлт хийж байгаа бөгөөд өөрчлөлт шинэчлэлтийн явцад өмнөд болон төвийн бүс нутгаа хөгжүүлэхэд ихээхэн туршлага хуримтлуулсан билээ. Энэхүү туршлагыг эдүгээ баруун бүс нутгийг хөгжүүлэхэд хэрэгжүүлж байна.

Баруун бүс нутгийг хөгжүүлэх талаар Хятадын удирдлага ихээхэн анхаарал тавьж ажиллав. Тухайлбал, 2004 оны 3 дугаар сарын 19-20-нд БНХАУ-ын Төрийн Зөвлөлөөс Баруун бүс нутгийг хөгжүүлэх тухай ажлын хурлыг Бээжинд хуралдуулж, Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Вэнь Цзябао өөрийн биеэр тус хурлыг удирджээ. Тэрээр илтгэл тавьж хэлсэн үгэндээ, Засгийн газраас боловсруулсан Баруун бүс нутгийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлсэн 4 жилийн хугацаанд уг бодлого нь зөв бодлого болохыг нотлон харуулсан бөгөөд бодит хэрэгт яв цав нийцэж байгааг тэмдэглэжээ. Вэнь Цзябао цааш нь Баруун бүс нутгийг хөгжүүлэх эцсийн зорилтонд хүргэхэд асар их ажил хийх шаардлагатай, нэлээд бэрхшээлтэй боловч Төв Засгийн газар энэхүү бодлогыг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх болно хэмээн онцлон тэмдэглэжээ.<sup>1</sup>

БНХАУ-ын баруун бүс нутгийн нэг өвөрмөц онцлог бол энэ нутаг дэвсгэр дээр гол төлөв хятадын үндэстний цөөнх амьдардаг бөгөөд ӨМӨЗО, ТӨЗО, СУӨЗО, Хөхнуур, Ганьсу зэрэг муж, өөртөө засах орнууд оршдог. Баруун бүс нутагт орших эдгээр өөртөө засах орон, мужууд нь гео-эдийн засгийн хувьд төдийлөн тааламжтай бүс. Ихэнхи газар нутаг нь өндөр уул, говь бүсэд хамаарах бөгөөд хөгжлийн хувьд Хятадын бусад эдийн засгийн бүсүүдтэй харьцуулахад нэлээд хоцрогдонгуй.

Хөхнуур муж Хятадын баруун бүс нутагт багтах бөгөөд Ганьсу, Сычуань, ТӨЗО, СУӨЗО зэрэг өөртөө засах орон, мужуудтай хиллэн, 721,2 мянган хавтгай дөрвөлжин км талбайтай, хүн ам нь 5,18 сая /2000 оны хүн амын тооллогоор/ юм.

Хөхнуур муж байгалийн нөөц баялгаар нэлээд арвин, одоогийн байдлаар 123 төрлийн ашигт малтмалтай, ялангуяа кали, натри, лити, магни, асбестийн нөөцөөр нэлээд их билээ. Газрын тос, байгалийн хийн

\*Н.Төмөр - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

талбай Цайдамын хотгорын баруун хойд хэсэгт орших бөгөөд нийт 0.2 тэрбум тн газрын тос, 293.7 тэрбум шоо дөрвөлжин метр байгалийн хийн нөөцтэй. Голмуд хотод жилд 1 сая тн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэр ажиллаж байна. Өнгөт металлаас хар тугалга 1150 мян.тн, цайр 1530 мян.тн, зэс 1800 мян.тн нөөцтэй байхаас гадна алтны хүдрийн нөөц мөн нэлээд ихтэй. Өнгөт металлын уул уурхайн аж үйлдвэрийн үндсэн дээр Хөхнуур мужид хөнгөн цагаан, цагаан тугалга, магни зэрэг өнгөт металл боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх бололцоотой. Эдүгээ жилд 200 мян.тн хөнгөн цагаан үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр Хөхнуур мужид ажиллаж байна.

Хөхнуур муж нь Хятадын мал аж ахуйн хөгжлийн чухал газар нутгийн нэг бөгөөд ашиглаж болох бэлчээрийн хэмжээ нь 33450 мян.гектар байна. Тус муж нийт 200 сая гаруй толгой малтайгаас 50 сая нь сарлаг бөгөөд хятадын бүх сарлагийн 50 хувийг эзэлнэ.<sup>2</sup>

2000 оны байдлаар Хөх-нуур мужийн ДНБ-ний хэмжээ 26.3 тэрбум юаньд хүрчээ.<sup>3</sup> Тус мужийн гео-экологийн байдлыг сайжруулах талаар нэлээд их ажил зохиож, арга хэмжээ авч гео-экологийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилгоор 2000 онд 18 мян. гектар газар тариалангийн талбайг ойжуулсан бөгөөд энэхүү ажлыг цаашид ч үргэлжлүүлж ойрын 10 жилд 333,3 мян. гектар газрыг ойжуулах зорилт тавьжээ.<sup>4</sup>

Улс ардын аж ахуйн аливаа салбарыг хөгжүүлэхэд болон ард иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл чухал үүрэгтэй билээ. Хөхнуур мужид одоогийн байдлаар жилд нийт 3280 мян.кв/цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай 2 усан цахилгаан станцтай бөгөөд 2015 он гэхэд 13 усан цахилгаан станц барьж байгуулан жилд 36,6 тэрбум кв/цаг эрчим хүч үйлдвэрлэхээр төлөвлөжээ.<sup>5</sup>

Хятадын эрдэмтэд Хөхнуур мужийг 3 үе шаттайгаар хөгжүүлэх санал дэвшүүлэв. Үүнд: нэгдүгээр үе шат, 2000-2005 онд дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ болон санхүү эдийн засгийн орлогын хэмжээг жилээс жилд 10%-иар, хөдөө нутгийн хүн амын дундаж орлогыг 6%-иас доошгүй, хот суурин газрын хүн амын дундаж орлогыг 8%-иас доошгүйгээр тус тус өсгөн, дэд бүтцийн бүтээн байгуулалт, эдийн засгийн зохицуулалт, экологийн байдлыг сайжруулах талаар анхны алхамыг хийсэн байх., хоёрдугаар үе шат, 2006-2015 онд хөгжлийн шинэ үе шатанд орж, Хятад улсын бусад газар нутгийн хөгжлийн түвшинд дөхүүлэн ойртуулж, хөгжлийн зөрөөг багасган, Хөхнуур мужийн

онцлогтой эдийн засгийн хөгжлийн загвар механизмыг бий болгон, ард иргэдийн амьжиргааг бага зэрэг чинээлэг түвшинд хүргэх, гуравдугаар үе шат, 2016-2050 онд нийгэм эдийн засгийг бүх талаар хөгжүүлэн, эдийн засгийн хөгжлийн түвшин болон ард иргэдийн амьжиргааны түвшинг Хятад улсын бусад газар нутгийн хөгжлийн түвшинд ойртуулах буюу хүргэсэн байх. Хөхнуур мужийн эдийн засгийг хөгжүүлэхэд хөрш ӨМӨЗО, ТӨЗО, СУӨЗО, Ганьсу муж зэрэг өөртөө засах орон, мужуудтай улс ардын аж ахуйн бүх салбарт хамтран ажиллаж, уул уурхай, эрчим хүч, газрын тос боловсруулах химийн үйлдвэр, нуурын давс боловсруулах химийн үйлдвэр, орон нутгийн онцлогтой хөдөө аж ахуй, аялал жуучлалыг давын өмнө хөгжүүлэх шаардлагатай хэмээн Хятадын эрдэмтэд үзжээ.

#### **Ишлэл зүүлт:**

1. “Жэньминь жибао” сонин, 2004.03.20
2. “Хятад улсын баруун бүс нутаг-Хөхнуур муж”, Бээжин, 2001, 35 дахь тал.
3. Ли Шаньтун. Баруун бүс нутгийг нээн хөгжүүлэх ба орон нутгийн хамтын хөгжил, Бээжин, 2003, 542 дахь тал.
4. “Хятад улсын баруун бүс нутаг-Хөхнуур муж”, Бээжин, 2001, 81, 92 дахь тал.
5. Мөн номын 82 дахь тал.

#### **Ашигласан ном хэвлэл:**

1. “Questions and answers on West China”, Sichuan, 2001
2. “Construct the strategic height at West China”, Sichuan, 2000
3. “Китай-2003”, Пекин, 2003
4. Ли Шаньтун. Баруун бүс нутгийг нээн хөгжүүлэх ба орон нутгийн хамтын хөгжил, Бээжин, 2003
5. “Хятад улсын баруун бүс нутаг-Хөхнуур муж”, Бээжин, 2001
6. Хуан Суцзянь. Баруун бүс нутгийг нээн хөгжүүлэх ба Зүүн, Төв бүс нутгийн хөгжил, Бээжин, 2001
7. “Олон улс судлал” сэтгүүл, 2003, №3
8. “Солонго” сэтгүүл, 2002, №8., 2004, №5